



Centrum na podporu integrace cizinců

Karlovarský kraj

Үзүүлэх үйлчилгээнүүд



нийгмийн асуудлаар мэргэжлийн зөвөлгөө



хууль эрхзүйн талаарх зөвөлгөө



Чех хэлний дамжаа



нийгэм соёлын дамжаа



орчуулага



интернет үйлчилгээ ба номын сан



боловсрол дээшлүүлэх арга хэмжээнүүд



Энэ үйлчилгээ хэнд зориулсан вэ

- гадаадын иргэдийн оршин суух тухай хуулийн дагуу БНЧУ-д хууль ёсоор удаан хугацаагаар оршин сууж буй гадаадын иргэд,
- олон улсын хамгаалалтанд байгаа хүн - цагаачилал, тусгай хамгаалалт,
- дээрх бүлэгт харьяалагддаггүй, дээрх бүлгүүдтэй ижил төстэй интеграцийн хэрэгцээтэй хүмүүс



Эдгээр үйлчилгээнүүдийг манай Төвд ҮНЭГҮЙ ашиглах боломжтой, мөн сонирхолтой дамжаа ба зөвөлгөөг Карловы Вары аймагт зохион байгуулж байгаа бүх газраас авч болно.



нийгмийн асуудлаар мэргэжлийн зөвөлгөө



Төвийн үйл ажиллагааны хүрээнд мэргэжлийн нийгмийн зөвөллөгөө үйлчилгээ 108/2006 тоот хуулийн дагуу бүртгэгдсэн. Эдгээр зөвөллөгөөг Төвийн нийгмийн ажилтнуудаар дамжуулан хэрэгжүүлж байгаа. Энэхүү үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээллийг www.integracnicentra.cz вэбсайтийн мэдээллийн материалаас буюу нийгмийн үйлчилгээний бүртгэлээс авах боломжтой.

Танд энэ талаар зөвлөх ба туслах:

- оршин суух асуудал
- нийгмийн хангамж ба тэтгэмж
- эрүүлийг хамгаалах асуудал ба эрүүл мэндийн даатгал
- байр орон сууц хөлслөх, хөдөлмөрийн зах зээл, боловсрол ба сургууль
- аливаа тулгамдсан асуудлууд – хүүхэдтэй болох, гэрлэх, ойр дотны хүн нас барах
- албан маягтуудыг бөглөх, албан байгууллага руу хамт явж асуудал хөөцөлдөх



орчуулах



Нийгмийн ажиллагаа, зарим сонгосон Чех хэлний дамжаа, нийгэм соёлын дамжаа эсвэл боловсрол эзэмших дамжаа, чөлөөт цагаар зохиогдож байгаа янз бүрийн соёл урлаг ба спортын уулзалтанд орчуулагч байна.

Вьетнам, монгол, украин, орос, англи ба хятад хэлний орчуулагч нар байгаа.



чех хэлний дамжаа

АНХАН ШАТНЫ

- чех хэл маш бага мэддэг хүнд зориулсан
- сургалтанд тогтмол биш явах ба нэг удаа ирэх
- энэ сургалтанд бүртгүүлэх шаардлага байхгүй

Эмнэлэг, албан байгууллага, худалдаа үйлчилгээний газруудад чехээр ойлгох анхан шатны мэдлэгийг танд олгоно.

ЭРЧИМТЭЙ ШАТНЫ

- чех хэлний зохих мэдлэгтэй хүнд зориулсан; багш тохируулан бүлэгт хуваарилана
- хичээл нь хоорондоо уялдаатай байдаг тул тогтмол явж байх нь ашигтай
- сурагчдын тоо хязгаартай тул урьдчилан бүртгүүлэх шаардлагатай

Ажилд орох ярилцлага зэрэг нилээн нухацтай зүйлийг амархан ойлгодог, ярилцдаг болно. Чех хэлний зохих түвшний шалгалтанд бэлтгэхэд танд тус болно.





§ хууль эрхзүйн талаарх зөвөлгөө

Хуваарьт цагуудад төв дээр хуульч байх бөгөөд гол нь дараах асуудлаар зөвлөнө:

- оршин суух зөвшөөрөл болон бүх визийн асуудлын талаар
- хөдөлмөр - эрхзүйн харьцаа
- өр, зээл, өр барагдуулах талаар
- албан татварын талаар

Хуулийн зөвөлгөө өгөх тодорхой хувиарыг www.integracnicentra.cz хуудаснаас мэдэж болно. Зөвөлгөө авах өдөр цагаа утсаар эсвэл биечлэн ирж ярьж тохирвол бусад үед хүлээх шаардлагагүй болно.

Нийгэм соёлын дамжаа

- энэ дамжаанаас Чех улсын талаарх үндсэн мэдлэг, нийгмийн талаар, эрүүл мэнд ба боловсролын системийн талаар мэдлэгийг олж авах
- албан байгууллагатай ба ажил олгогчтой хариулж чаддаг болох
- Чех улсын иргэнийг хүсэхэд Чех улсын талаарх мэдлэгийн шалгалтыг хийхэд танд тус болно

Өдөр тутмын амьдралд тохиолдох асуудал, нутгийн хүмүүстэй хэрхэн зөв харьцах, худалдаа хийх, ресторан хоол захиалах, Чех улсаар аялах жуулчлах гэх мэт сэдвээр жишээлэн ярилцаж туршина. Мөн Чех улсын түүх ба газар зүйн талаар танилцан мэдэж авна.



интернет үйлчилгээ номын сан

- интернетээр үнэгүй үйлчилж болно
- интернетээр хурдан мэдээлэл хайх ба авах, жиш. ажил ба байр хайх
- номын санд англи, франц, орос, украин, вьетнам, хятад зэрэг хэл дээр ном, сонин сэтгүүлүүд бий.

Хэрэв компьютер дээр болон интернеттэй ажиллаж чадахгүй бол танд дуртай зөвлөж, тусалж, тайлбарлаж өгнө.

боловсрол дээшлүүлэх арга хэмжээнүүд

Танин мэдүүлэх, боловсрол мэдлэг дээшлүүлэх арга хэмжээнүүдийг хүүхэд залуус, насанд хүрэгсдэд зориулан мэргэжлийн болон ерөнхий байдлаар зохион байгуулна.

Эдгээр арга хэмжээг сургууль, хүүхэд залуусын болон бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулна.



интернет хуудас
www.integracnicentra.cz



ТӨВИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

Даваа	12:00 – 18:00
Мягмар	<i>дотгоод ажилтай</i>
Лхагва	12:00 – 18:00
Дүрэв	08:00 – 12:00
Баасан	08:00 – 12:00



Холбогдох

tel.: +420 353 892 559

mobil: +420 608 119 878


+420 773 779 022

e-mail: ickarlovyvary@suz.cz

хаяг

Centrum na podporu integrace
cizinců – Karlovarský kraj

Závodu Míru 876/3a
360 17 Karlovy Vary



Centra na podporu
integrace cizinců



SPRÁVA
UPRCHLICKÝCH
ZAŘÍZENÍ MV